**7-р цэг:** Ургамлын бүрхэцийн өндөр 3-4см, ургамал хоорондын зай 2-30см, хагд өвсний хуримтлал бага зэрэг, хөрсөнд элэгдэл эвдрэлийн шинж байхгүй. Зүйлийн тоо 8, үетэн 3, шарилж 3, сонгинолог 2. Малын баас ихтэй.

**Дүгнэлт:** Ургамлын зүйлийн тоо 7 цэгт харилцан адилгүй байгаа бөгөөд торлолын аргаар тодорхойлсон нь зөвхөн санамсаргүй байдлаар 1м<sup>2</sup> талбай сонгож зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлсоноос шалтгаалан зүйлийн тоо цөөн байна. Судалгаанд хамрагдсан нийт талбайд хялгана, үетний эзлэх хувь өндөр байгаа нь бэлчээр талхлагдалд ороогүй, уурхайн ашиглалт нь бэлчээрийн ургамлын зүйлд одоогоор сөрөг нөлөөлөл үзүүлээгүй байна. Мөн үлийн цагаан оготны тархалт ажиглагдаагүй. 1, 2, 5-р цэгийн талбайн ургамал хоорондын зай их, ургамал сийрэг байгаа нь хөрс салхинд хийсэх, усанд урсах нөхцөлийг бүрдүүлж байна. Хагд өвсний хуримтлал бага хэмжээгээр үүсч байгаа нь 2022 онд ургамлын гарц нэмэгдэж байгааг харуулж байна. Уурхайн нөлөөлөлд өртөж болзошгүй 4, 7-р талбайг фон цэгээр сонгон дүгнэлт хийхэд хөрсний элэгдэл эвдрэл үүсээгүй бөгөөд хагд өвсний хуримтлал үүсч, ургамлын зүйлийн ихэнх хувийг хялгана, үетэн эзэлж байгаа нь бэлчээрийн ургамалд өөрчлөлт ороогүйг илтгэнэ. /Ургамлын зургуудаас нотлогдоно./

#### **3.4.1.2. Кемпийн орчинд зүлэг болон мандлын цэцэг тариалан, арчилж тордох ажлыг тогтмол гүйцэтгэх**

- ✚ Гал тогоо болон ажилчдын кемпийн өмнө талбайд цэцэг тарих газрыг бэлтгэн хайс татаж, 2 төрлийн цэцгийг **30м<sup>2</sup>** талбайд тариалан, усалгаа арчилагааг тогтмол хийж гүйцэтгэлээ. Цэцэг услахад зориулж цэцэг усалгааны зориулалтын сав авч усалгааг хийлээ. Цэцэгний үр боловсорч гүйцэсний дараа түүж нөөцлөв. Цэцэг тарих хайс хийх, талбайн хөрс бэлтгэх, цэцэг тарих ажилд нийт 5 ажилтан оролцов.





*Зураг 117. Цэцэг тарих газарт хайс хийж буй нь*

Салбар, урагн зөвлөл, үйлд, худалдаа, үйлчилгээний байрны дараахь 2023 оны 6-р сарын 15-ны 174-дугаар тухайн хэргийг

**НЭХЭМЖЛЭХ №** .....

Насжилт: Байгууллагын нэр: Сайрагч ХХК Төлөөч: Баянхонгор  
 Хайр: Мария гол Хайр: Хөвсгөл сум  
 Утас: 77735080 Хайр: 76099010  
 Э.чуулан: 86108255 Гэрээний №: SSOW298  
 Банкны нэр: Осаан Банк Нөхцөлөөсний өгсөн: 2023.05.20  
 Банкны дансны дугаар: 5021660900 Нөхцөлөөсний өгсөн: 2023.05.20  
 Регистрийн №: 5010071 Төлбөр хийх хугацаа: 2023.06.02

№	Тайлбартай утга	Төгс хэмжээ	Налаартай үнэ	Нийт үнэ
1	Аж / 192мм	7	1100	7700
2	Аж / 130 / 130 / 22	7	52950	369950
3	Аж / 130 / 130 / 22	2	2250	4500
4	Аж / 130 / 130 / 22	10	2250	22500
5	Аж / 130 / 130 / 22	1	4850	4850
6	Аж / 130 / 130 / 22	1	2250	2250
7	Аж / 130 / 130 / 22	10	2250	22500

Мөнхийн дүн: 138480

Нөхцөлөөсний өгсөн: 2023.05.20

**КАССЫН ЧӨР**

СӨБӨЛЖ ХХК  
 Салбар: Соёмго дотуур  
 Утас: 77735080  
 Банкны нэр: Осаан Банк  
 Банкны дансны дугаар: 5021660900

**НӨАТ-С НӨНӨЛӨГӨДӨН ҮЭРЭГ**

СӨБӨЛЖ ХХК  
 Салбар: Соёмго дотуур  
 Утас: 77735080  
 Банкны нэр: Осаан Банк  
 Банкны дансны дугаар: 5021660900

Заралын нэр	Тог	Үнэ	Нийт үнэ
Цэцэг-дүр Зөвлөлөгч	1	72.830	+ 72.830
Төл-дүр Зөвлөлөгч	1	4.850	+ 4.850
Төл-дүр Зөвлөлөгч	1	22.450	+ 22.450
Цэцэг-дүр Зөвлөлөгч	4	2.800	+ 11.200
Цэцэг-дүр Зөвлөлөгч	16	2.800	+ 44.800

Нийт үнэ: **138.480**

Нөхцөлөөсний өгсөн: **2023.05.20**

Зураг 118. Цэцэг болон зүлэг услах багаж авсан төлбөрийн баримт




Зураг 119. Зүлэг, цэцэг арчлах болон услах усалгааны багаж





Зураг 120. Цэцэг тарьж буй нь







*Зураг 121. Цэцгийн усалгаа хийж буй нь*



*Зураг 122. Цэцэг ургасан байдал*





*Зураг 123. Цэцгийн үр түүж буй нь*







- ✚ Ажилчдын кемпийн дунд талд 8x8, 8x8, 13x8 хэмжээтэй талбайд зүлэг тарих талбайн хөрсийг бэлтгэж, зүлэг тарих зааврын дагуу 25 кг үрийг тарьж, элсээр хучин, арчилгаа тордолгоо, усалгааг хийлээ. Зүлэг услах усалгааны багаж авч, усны машины усны хоолойд залган усалгааг нормын дагуу хийж гүйцэтгэлээ.
- ✚ Зүлэгний 1 кг үр нь 40000 төгрөг, нийт 1 сая төгрөг, багаж хэрэгсэлд 154000 төгрөг, нийт **1154000** төгрөг зарцууллаа. Зүлэг тарих ажилд уурхай болон үйлдвэрийн нийт 17 ажилтан хамрагдав. Зүлэг тарьсан талбай **232м<sup>2</sup>**







*Зураг 124. Зүлэг тарих талбайн хөрсийг бэлтгэж буй нь*





*Зураг 125. Зүлэг тарьж буй нь*





Зураг 126. Зүлэг тарьсны дараах усалгаа хийж буй нь





*Зураг 127. Зүлэгний ургалтын байдал*



*Зураг 128. 10-р сарын цэнэг усалгаа хийж буй нь*

Цэцгийн мандлын усны тооцоо:  $30\text{м}^2$  талбайд 6 сараас 9 сар хүртэл 7 хоногт 2 удаа усалгаа хийнэ гэж тооцвол:

Хоногт:  $30\text{м}^2 * 4.0\text{л} = 0.12\text{м}^3/\text{хон}$

Жилд:  $30\text{м}^2 * 4.0\text{л} * 32 = \underline{3.84\text{м}^3}/\text{жил}$  ус хэрэглэсэн.

### **3.4.1.3. Кемпийн орчны явган зорчих хэсгийн зам талбайг засаж сайжруулах**

- ✚ Кемпийн өмнөх автомашины зогсоолоос кемп хүртэл **20.5x1.80м** талбайд явган хүний зорчих хэсгийн замыг шинээр хийж, өмнө жилүүдэд тавигдсан зорчих хэсгийн замын чулууг тэгшилж, усаар түрэгдэж урссан чулуу, хайргыг засаж сайжруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.





*Зураг 129. Зорчих хэсгийн замыг шинээр тавьж буй нь*



Мод усалгааны тооцоо: Нийт 3350ш модыг жилд 14 удаа усална гэж тооцвол:

Хоногт:  $3350\text{ш} \cdot 40.0\text{л/хон} = 134.0\text{м}^3/\text{хоног}$

Жилд:  $3350\text{ш} \cdot 40.0\text{л/хон} \cdot 8 = 1879.0\text{м}^3/\text{жил}$

Мод болон ногоон байгууламжийн усалгаанд нийт **2156.0м<sup>3</sup>** ус хэрэглэсэн байна.



### 3.5 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний гүйцэтгэл

#### 3.5.1.1. Уурхайн орчинд мал, амьтан орж ирэхээс урьдчилан сэргийлж харуул хамгаалалтыг сайжруулах

Уурхайн бүсэд мал, зэрлэг амьтан орж ирэхээс урдчилан сэргийлэх үүднээс 24 цагийн харуул хамгаалалт, хяналтын байнгын 5 пост гарган ажиллаж байна.



Зураг 130. 24 цагийн харуул хамгаалалтын байр

#### 3.5.1.2. Өндөр хүчдэлийн шон дагуу байрлуулсан шувуу үргээгчийн ажиллагааг хянах, эвдэрсэн шувуу үргээгчийг засварлах

Манай компани нь 2018 онд махчин шувуудыг цахилгаан хүчдэлд цохиулж үхэх эрсдэлийг бууруулах үүднээс уурхайн ашиглалтын талбайн ойр орчмын өндөр хүчдэлийн шугам татсан 12 км газрыг хамарсан талбайд нийт 127 ширхэг цахилгааны шонд шувуу үргээгч суурилуулсан ба жил бүр шувуу үргээгчийн бүрэн бүтэн байдал, өндөр хүчдэлийн цахилгааны шонгийн ойр орчимд тогонд цохиулж эндэж бэртсэн шувуу байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж байна. 2022 онд шувуу үргээгчүүд хэвийн ажиллаж байгаа бөгөөд тогонд цохиулж эндсэн шувуу байхгүй байна.





**5.5.1.3. Ил уурхайн карьерт мал, амьтан орохоос сэргийлж хашаа хайс татах, бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавих, засаж сайжруулах, тэмдэг тэмдэглэгээ байршуулах**

1, 2, 3, 4-р биетийн ил уурхайн карьерийн урд хэсгээс дээд хэсэг хүртэл татсан хашаа, хайсны эвдэрсэн хэсгийг сольж шинэчлэн, засаж сэлбэх ажлуудыг хийж гүйцэтгэв.



*Зураг 132. Ил уурхайн карьерийн хашаа хайсыг засаж сэлбэсэн байдал*

#### **3.5.1.4. Шаардлагагүй үед дуут дохио гаргахгүй байх талаар тээврийн хэрэгслийн жолооч нарт зөвлөмж өгч ажиллах**

Уулын ажил шөнийн цагаар гүйцэтгэхийн өмнө Уулын мастер шаардлагагүй үед дуут дохио гаргахгүй байх талаар тээврийн хэрэгслийн жолооч нарт зөвлөгөө өгч ажиллаж байна.

#### **4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, “Байгаль орчин, геологи уул уурхайн хууль тогтоомжийн эмхэтгэл”, “Ашигт малтмалын тухай” хууль, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль болон бусад хууль, тогтоомж, дүрэм, журам, аргачлалын дагуу уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг уурхайн үйл ажиллагааг явуулж байгаа аж ахуй нэгж байгууллага Монгол улсын стандартын дагуу зайлшгүй хийсэн байх үүрэгтэй.

Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны 2022 оны тайлангаар Уурхай орчмын 11.82 га газар нөлөөлөлд өртсөн болохыг тогтоосон. Нөлөөлөлд өртсөн талбайгаас 0.1 га газарт техникийн нөхөн сэргээлт хийгдсэн. Ил уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн. Мөн үйлдвэрийг ажиллуулах явцад хаягдлын аж ахуйг нөхөн сэргээж, техникийн



тусламжтайгаар хаягдлын өтгөн хэсгийг шүүн ачиж, дотоод овоолгоор нөхөн сэргээлт хийх, үйлдвэр, кемпийн орчинд ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж өмнөх жилүүдэд мод тарьсан талбайд нөхөн тарилт хийх зорилгоор энэхүү төлөвлөгөөг боловсруулсан болно.

#### 4.1. Хүдрийн 1, 2, 3-р биетийн карьерийн хоосон орон зайд дотоод овоолго хийх /5000 м<sup>3</sup>/

2023 онд баяжуулах үйлдвэр нь тогтмол үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд хуурай хаягдал үүсээгүй. 2022 онд үүссэн хуурай хаягдлаар дүүргэлт хийж, хэвгийжүүлж нягтаршуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.




*Зураг 133. Хуурай хаягдлаар дүүргэлт хийж буй нь*


#### 4.2. Хүдрийн 5-р биетийн карьерийн хоосон орон зайд дүүргэлт хийх /30000 м<sup>3</sup>/

5-р хүдрийн биетийг 2021 онд бүрэн ашиглаж дууссан бөгөөд маркшейдерийн хэмжилт, нөөцийн хөдөлгөөнийг баталгаажуулж, АМГТГ-т тайлагнан хүдрийн биетийг хаасан. Иймээс 5-р хүдрийн биетийн ухашийг булах, дүүргэлт хийх техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 2022 онд эхлэсэн. 2022 онд нийт **32936м.куб** дотоод овоолго хийсэн бөгөөд 2023 онд 5-р биетэд дотоод овоолгоор дүүргэлт хийх ажил уулын ажил тогтвортой явагдаагүйн улмаас хурдас чулуулгийн дутагдлаас бага хэмжээнд хийгдэж, тоон мэдээлэл гаргах боломжгүй байсан. 5-р биетийн хүдрийн овоолгын нөхөн сэргээлтийг бүрэн хийж дуусгасан.

Ил уурхайн ухшийг дотоод овоолгоор дүүргэлт хийхэд чулуулгийн гулсалт, нуралтын аюулгүй байдлыг тооцон осол авааргүй ажлыг гүйцэтгэлээ. 5-р биетийн отвалын нөхөн сэргээлт хийсэн гадаргуугийн налуу нь 9<sup>0</sup> -14<sup>0</sup>





Зураг 134. Нөхөн сэргээлтийн өмнөх байдал



Зураг 135. Нөхөн сэргээлтийн дараах байдал







Зураг 136. Нөхөн сэргээлтийн өмнөх байдал


Хүснэгт 13. 5-р биетийн отвалын координат

ID	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд	Long	Lati
1	99	35	10.222	46	20	29.456	99.63285	46.37478
2	99	35	7.769	46	20	28.6	99.58549139	46.34127778
3	99	35	5.46	46	20	28.627	99.58485	46.34128528
4	99	35	3.211	46	20	30.082	99.58422528	46.34168944
5	99	35	3.385	46	20	31.679	99.58427361	46.34213306
6	99	35	4.649	46	20	32.417	99.58462472	46.34233806
7	99	35	6.959	46	20	32.483	99.58526639	46.34235639
8	99	35	7.96	46	20	31.795	99.58554444	46.34216528
9	99	35	8.871	46	20	31.5	99.5857975	46.34208333

Техникийн нөхөн сэргээлт хийхийн өмнөх байдал:



*Зураг 137. 5-р биетийн ухшийн дотоод овоолгын нөхөн дүүргэлт хийхээс өмнөх байдал*



*Зураг 138. 5-р биетийн овтал нөхөн сэргээлт хийхийн өмнөх байдал*





*Зураг 139. 5-р биетийн шимт хөрсний овоолгыг тэмдэгжүүлсэн байдал*

*Зураг 140. Нөхөн сэргээлт хийхээс өмнөх байдлууд*

**Нөхөн сэргээлт хийж буй болон дараах байдал:**







*Зураг 141. 5-р биетийн дотоод овоолгын нөхөн сэргээлт*



*Зураг 142. 5-р биетийн отвалын нөхөн сэргээлт хийжэ буй нь*





Зураг 143. Нөхөн сэргээлт хийсний дараах байдал

**Дүгнэлт:** 2023 онд 1, 2, 3-р хүдрийн биетийн хаягдлын дотоод овоолгоор хийх, 5-р биетийн дотоод овоолгын нөхөн дүүргэлтүүд нь баяжуулах үйлдвэр, уурхайн үйл ажиллагаа тогтмол явагдаагүйн улмаас бага хэмжээгээр хийгдсэн ч, 5-р биетийн отвалын нөхөн сэргээлтийн ажлыг 100 хувь хийж гүйцэтгэн, нийт **1.3 га** буюу **12990м<sup>2</sup>** газарт отвалын нөхөн сэргээлт болон дээрх ажлуудад нийт 6 ажилтан, 2 хүнд даацын автомашин, **13,780,380.0** төгрөг зарцуулсан байна.

#### **4.3. Уурхайн ногоон байгууламжийн талбайд нөхөн тарилт хийх**

Уурхайн эдэлбэр газрын хэмжээнд 2019 оноос 2022 онуудад нийт 1350 ш мод тариалсан боловч 2021, 2022 онуудад уурхайн үйл ажиллагаа тогтвортой явагдаагүйн улмаас модны арчилгаа, тордолгоо хийгдээгүй, мөн намар, өвлийн цагт мал орсон улмаас нийт тариалсан модны ихэнх нь устаж үгүй болсон.

Мод тарихын өмнө дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- ✚ Өмнө жилүүдэд мод тарьсан талбайнуудын хог хаягдлын цэвэрлэгээг зохион байгуулав.
- ✚ Талбай тус бүрээр нөхөн тарилт хийх модны тоог гаргав.

- ✚ Шинээр мод тарих талбайг бэлтгэж, тарилтад хэрэглэгдэх бууц, элс, хүрэн хөрс зэргийг татаж бэлтгэв.
- ✚ Хавар, намрын мод тарих үзэсгэлэн худалдаанд оролцож, 1500ш хайлаас, 500ш улиас, нийт 2000 ш модны тарьц суулгацыг Улаанбаатар хот, Хэнтий аймгийн Бнндэрийн Ойн аж ахуйгаас захиалан авчирч, хаврын тарилт 2023 оны 5-р сарын 12-оос бэлтгэл ажлыг зохион байгуулж, 15-18-ны өдрүүдэд, намрын тарилтыг 10-р сарын 15-17-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж, уурхайн нийт 51 ажилчид уг ажилд оролцлоо. Мод тарихад нийт **4,400,000.0 төгрөг** зарцуулав.
- ✚ Өмнө жилүүдэд мод тарилт хийсэн нийт 7 талбайн 0.7 га газарт улиас 152 ш, хайлаас 750ш, нийт **902 ш** тарьц нөхөн тарилтад тариаллаа.

### Нөхөн тарилтын явцаас:



*Зураг 144. 5-р сард нөхөн тарилт хийж буй нь*







Зураг 145. Нөхөн тарилт хийсэн талбайнууд



Зураг 146. 10-р сарын нөхөн тарилт хийж буй нь



**Модны ургалтын байдал:**







*Зураг 147. Зуны ургалтын байдал*



Зураг 148. Уурхайн талбайд мод тарьсан талбайнуудын байршил

#### 4.4. Химийн бодисын агуулахын үрд талд шинээр талбайд мод суулгац тарих



Зураг 149. Баяжуулах үйлдвэрийн баруун урд талд шинээр мод тарьсан талбайн байршил

Хүснэгт 14. Шинээр тариалсан талбайн координат

ID	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд	Long	Lati
1	99	35	23.1216	46	21	18.8208	99.63285	46.37478
2	99	35	23.676	46	21	18.1692	99.58549139	46.34127778
3	99	35	22.7256	46	21	17.8308	99.58485	46.34128528
4	99	35	22.182	46	21	18.504	99.58422528	46.34168944

Шинээр мод тарих талбайд хэмжилт хийж, чулуу болон хог хаягдлыг цэвэрлүүлсэн.



- ✚ Шимт хөрс, хөх бууц, элс зэргийг бэлтгүүлсэн.
- ✚ Шинээр тарих талбайд хайлаасыг гудамлаж тарихаар сонгосон бөгөөд тарилт хоорондын зүйг 1м, 3ш-ээр багцлан 5-р сард 300ш, 10-р сард 200ш хайлаас, 128 ш улиас, нийт **628ш** тарьц суулгац тариалсан. Улиасыг 60х70 см-ын диаметртэй, 50х60 см-ын гүнтэй нүх бэлтгэн, мод хоорондын зайг 2м-ээр тооцон 30х30 буюу 900м<sup>2</sup> талбайд тарилтыг хийж гүйцэтгэв.
- ✚ Мод тарих ажилд нийт 51 ажилчид оролцов.
- ✚ Талбайд ургасан зэрлэг ургамлыг түүж цэвэрлэсэн.

**Мод тарилтын явц болон үргэлжлэл:**





*Зураг 150. Шинээр тариалсан мод 5-9 сарын хугацаанд ургасан байдал*





Зураг 151. 10-р сарын нөхөн тарилт

#### 4.5. Бөмбөгөр сумын Цэцэрлэгт хүрээлэнд мод суулгац тарих



Зураг 152. Бөмбөгөр сумын Цэцэрлэгт хүрээлэнгийн талбайн байршил

ID	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд	Long	Lati
1	99	36	24.49	46	12	52.79	99.60680278	46.21466389
2	99	36	28.22	46	12	53.17	99.60783889	46.21476944
3	99	36	28.62	46	12	50.56	99.60795	46.21404444
4	99	36	24.81	46	12	50.28	99.60689167	46.21396667

- ✚ 2019 оноос 2022 он хүртэл тарьсан модны тоог гаргав.
- ✚ Талбайн хог хаягдлыг цэвэрлэж, мод тарих нүхийг ухаж бэлтгэлээ.
- ✚ Хашаа, хайсыг нөхөн сэлбэж засварлав.
- ✚ Цэцэрлэгт хүрээлэнд хавар 5-р сард 250 ш хайлаас, намар 10-р сард 220 ш улиас, **нийт 470 ш** мод суулгацыг тарьж нөхөн тарилтыг бүрэн хийж дуусгасан.
- ✚ Мод суулгац тарих ажилд 2 автомашин, 17 ажилтан оролцов.

**Мод суулгац тарилтын явцаас:**







*Зураг 153. 5-р сарын нөхөн тарилт*



*Зураг 154. 10-р сарын нөхөн тарилт*

#### 4.6. Усалгаа, арчилгаа, тордолт хийх

- ✚ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан мод суулгацын усалгаа, арчилгаа болон тордох ажлыг 4-р сарын 12-оос 10-р сарын 26 хүртэл, сард 2 удаа хийж гүйцэтгэсэн бөгөөд цэнэг усалгааг 10-р сарын 19-26-ны өдрүүдэд хийж гүйцэтгэлээ. Ногоон байгууламжийн усны хэрэглээг ус ашиглалтын бүртгэлд бүртгэж, усны төлбөрийн тооцоо, тайланг Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаанд хүргүүлж ажиллаа.
- ✚ Ногоон байгууламжийн усалгаанд зарцуулагдах усыг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны А/301 дугаар тушаалын 13-р хавсралтын 3 дугаарт 1 ш суулгац услах норм 40 л усаар тооцоход: 2019-2023 онуудад нийт 3350 ш суулгац тарьсан бөгөөд нийт 14 удаагийн усалгаа хийж, 1 удаагийн усалгаанд  $134\text{м}^3$ ,  $14 \times 134 = 1876\text{м}^3$  ус зарцуулсан байна.
- ✚ Бөмбөгөр суманд нийт 470ш мод нөхөн тарилтад, өмнө жилүүдэд тарьсан модноос 30ш мод, нийт 500ш мод, сард 2 удаа усалгаа хийхэд  $280\text{м}^3$  ус зарцуулсан байна.
- ✚ Ногоон байгууламжийн усалгаанд 2023 онд **нийт  $2156\text{м}^3$**  ус зарцуулсан.
- ✚ Ногоон байгууламжийн усалгаа, арчилгааг хийх ажилд 2023 оны 6-р сарын 1-ээс 10-р сарын 15 хүртэл Байгаль орчны туслахаар 2 ажилтан авч ажиллуулсан, цалинцууллаа.

#### Усалгаа болон арчилгаа хийж буй байдлууд:







*Зураг 155. Бөмбөгөр сумын Цэцэрлэгт хүрээлэнд мод тарих талбайн хашаа хайсыг сэлбэж буй байдал*











*Зураг 156. Бөмбөгөр сумын Цэцэрлэгт хүрээлэнгийн модны усалгаа, арчилгаа*













*Зураг 157. Уурхайн талбайд нөхөн тарилт хийсэн мод суулгацын услагаа*







Зураг 158. Шинээр тарьсан талбайн мод суулгацын усалгаа

**Дүгнэлт:** “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, нийгмийн хариуцлагын хүрээнд Бөмбөгөр сумын Цэцэрлэгт хүрээлэнд нөхөн тарилт хийх зэрэг ажлуудыг төлөвлөн, уурхайн ногоон байгууламжийн 7 талбайн **0.7 га** газарт улиас 152 ш, хайлаас 750ш, нийт **902 ш** тарьц суулгац, шинээр тариалсан **0.09 га** талбайд 128 ш улиас, 500ш хайлаас, нийт **628 ш** тарьц суулгац, Бөмбөгөр сумын Цэцэрлэгт хүрээлэнд **0.6га** талбайд 250ш хайлаас, 220ш улиас, нийт **470ш** тарьц суулгац, нийт **2000ш** тарьц суулгац тарьж, тарьц суулгацын усалгааг 4-р сарын 12-оос 10-р сарын 26 хүртэл сард 2 удаа, нийт 14 удаагийн усалгаа хийхэд **2156м<sup>3</sup>** ус зарцуулсан байна. Мод суулгац худалдан авахад **4,400,000.0** төгрөг карцуулав.

## **5.БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

### **5.1. Баянхонгор аймгийн БОАЖ-ын газраас ирүүлсэн саналын дагуу Бөмбөгөр сумын 1-р багийн “Зүүн холбоогийн иш” хэмээх газарт хууль бус олборлолтын улмаас эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийх**

БОННҮнэлгээний нэмэлт тодотгол (2021 онд “Ашид Ананда” ХХК-иар гүйцэтгүүлсэн) тайлангийн 6 дугаар бүлэг, “Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ, зөвлөмж, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ”, хуудас 152-157 “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ”, БОННҮ-ний тайлангийн БОМТөлөвлөгөөний 1.5 дах хэсэгт Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ (хуудас 15-16) Уул уурхайн олборлолтын улмаас нөхөн сэргээгдээгүй орхигдсон газарт нөхөн сэргээлт хийх гэсэн эдгээр заалтуудыг үндэслэн компанийн 2023 оны БОМТ-ний хуудас 44-д Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөнд Баянхонгор аймгийн БОАЖГазрын 2023 оны 5-р сарын 15-ны өдрийн 226 тоот Санал хүргүүлэх албан хүсэлтийн дагуу Бөмбөгөр сумын Улаан сайр 1-р багийн нутагт байрлах “Зүүн холбоогийн иш” нэртэй эвдрэлд орсон 5 га газарт техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж гүйцэтгэлээ.

Энэхүү ажлыг МУ-ын БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/138 тоот тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”, МУ-ын стандарт **MNS 5914:2008** “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага”, **MNS 5914:2008** “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт.Нэр томъёо, тодорхойлолт” эдгээр хууль эрх зүйн бичиг баримт, холбогдох стандартын дагуу хийж гүйцэтгэлээ.

Техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 2023 оны 8-р сарын 30-аас 9-р сарын 03-ныг дуустал нийт 5 хоногийн хугацаанд 8 хүн, 4 автомашин 10.0 га газрын техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. МУ-ын БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/138 тоот тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу Техникийн нөхөн сэргээлтийн зардалын тооцоог гаргалаа.

Техникийн нөхөн сэргээлт хийх газар нь уулс хоорондын хөндий, ам, жалганд байрлах бөгөөд тус газарт үүссэн эвдрэл, ашиглагдсан орон зайд дүүргэлт хийх, ухашийн ирмэгийг хэвгийжүүлэх, овоолго үүсгэсэн гадаргууг сийрүүлэн тэгшилж, налуу гадаргууг орчных нь



гадаргуугийн хэлбэр төрхтэй ойртуулан түрэх, хэлбэржүүлэх, тогтворжуулах, дэнжлүүлэн өндөрлөх, оройг нь намсгах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэв.



Зураг 159. Дүйцүүлэн хамгааллаар нөхөн сэргээх газрын байршил



Зураг 160. Нөхөн сэргээлт хийгдсэн талбай

Хүснэгт 16. Дүйцүүлэн хамгааллаар нөхөн сэргээлт хийсэн газрын солбицол

ID	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд	Long	Lati
1	99	37	58.248	46	22	29.215	99.632847	46.374782
2	99	38	02.716	46	22	23.712	99.634088	46.373253
3	99	38	06.303	46	22	19.318	99.635084	46.372033
4	99	38	06.542	46	22	17.859	99.63515	46.371627
5	99	38	05.931	46	22	14.770	99.634981	46.370769

6	99	38	07.118	46	22	12.510	99.635311	46.370142
7	99	38	09.697	46	22	09.270	99.636027	46.369242
8	99	38	14.367	46	22	04.671	99.637324	46.367964
9	99	38	18.889	46	22	03.873	99.63858	46.367742
10	99	38	19.881	46	22	06.828	99.638856	46.368563
11	99	38	21.219	46	22	06.643	99.639227	46.368512
12	99	38	21.329	46	21	59.640	99.639258	46.366567
13	99	38	20.679	46	21	53.149	99.639077	46.364764
14	99	38	18.227	46	21	50.865	99.638396	46.364129
15	99	38	15.689	46	21	46.638	99.637691	46.362955
16	99	38	17.749	46	21	42.738	99.638264	46.361872
17	99	38	23.593	46	21	40.396	99.639887	46.361218
18	99	38	27.049	46	21	35.728	99.640847	46.359924
19	99	38	24.143	46	21	32.806	99.64004	46.359113
20	99	38	22.129	46	21	29.725	99.63948	46.358257
21	99	38	22.146	46	21	25.748	99.639485	46.357152
22	99	38	25.426	46	21	22.460	99.640396	46.356239
23	99	38	25.171	46	21	17.028	99.640325	46.35473
24	99	38	26.025	46	21	13.643	99.640562	46.35379
25	99	38	24.940	46	21	13.693	99.640261	46.353804
26	99	38	24.087	46	21	17.122	99.640024	46.354756
27	99	38	24.340	46	21	22.334	99.640094	46.356204
28	99	38	20.931	46	21	25.534	99.639148	46.357093
29	99	38	20.855	46	21	29.930	99.639126	46.358314
30	99	38	22.995	46	21	32.878	99.639721	46.359133
31	99	38	24.751	46	21	35.697	99.640209	46.359916
32	99	38	22.374	46	21	39.774	99.639548	46.361048
33	99	38	17.161	46	21	41.527	99.6381	46.361535
34	99	38	14.351	46	21	46.822	99.63732	46.363006
35	99	38	15.222	46	21	50.418	99.637562	46.364005
36	99	38	18.395	46	21	54.311	99.638443	46.365086
37	99	38	20.240	46	21	59.337	99.638956	46.366482
38	99	38	18.482	46	22	01.865	99.638467	46.367185
39	99	38	01.884	46	22	03.443	99.636912	46.367623
40	99	38	05.957	46	22	11.456	99.634988	46.369849
41	99	38	03.699	46	22	14.870	99.634361	46.370797
42	99	38	04.128	46	22	18.844	99.63448	46.371901
43	99	38	00.426	46	22	24.388	99.633452	46.373441
44	99	37	57.225	46	22	29.133	99.632563	46.374759
45	99	37	58.248	46	21	29.215	99.632847	46.374782

Техникийн нөхөн сэргээлтийн ажлын явцын зургийг Дүйцүүлэн хамгаалах ажлын тайланд дэлгэрэнгүй тусгав.



**Техникийн нөхөн сэргээлтийн ажлын явц:**





*Зураг 161. Нөхөн сэргээлт хийхээс өмнөх байдлууд*







*Зураг 162. Нөхөн сэргээлт хийж буй байдлууд*



Зураг 163. Нөхөн сэргээлт хийж дууссаны дараах зургууд

**Дүгнэлт:** 2023 оны БОМТ-ний 7-р бүлэгт Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд Баянхонгор аймгийн БОАЖГазрын 2023 оны 5-р сарын 15-ны өдрийн 226 тоот Санал хүргүүлэх албан хүсэлтийн дагуу тус сумын 1-р багийн “ЗҮҮН ХОЛБООГИЙН ИШ” нэртэй газарт гар аргаар алт олборлогчдын ухаж эвдсэн 10.0 га газарт техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөн уг ажилд 4 техник, 8 хүн ажиллаж, 22,523,593.0 төгрөг зарцуулан ажиллаа.

## **5.2. Компанийн зардлаар дүйцүүлэн хамгаалал хийсэн талбайнуудад хаягийн самбар байршуулах**

- ✚ 2021 онд Бөмбөгөр сумын 1-р багийн Улаан жалга гэх газарт 5.0 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн газарт
- ✚ 2022 онд Бөмбөгөр сумын 1-р багийн Улаан жалга гэх газарт 5.0 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн газарт



- 2023 онд Бөмбөгөр сумын 1-р багийн Зүүн холбоогийн иш гэх газарт 10.0 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн газарт тус тус хаягийн самбар байрлуулахад 3 ажилтан, суудлын автомашин 1, хаягийн самбар 3ш, **237600 төг** зарцуулав.





*Зураг 164. Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайнуудад хаягийн самбар байрлуулж буй нь*

## **6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Тухайн төслийн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

## **7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

### **7.1. Төслийн талбайд орших Хүн чөлүүн хөшөөний хайсыг засварлан, тэмдэг тэмдэглэгээ байршуулах**

Хөхбулаг уурхайн 5-р биетийн отвалын замын зүүн хойд талд орших Түүх соёлын үл хөдлөх дурсгал болох Буган хөшөөний хашаа хайсыг  $9 \times 6 = 54 \text{ м}^2$  хэмжээтэй болгон шинэчилж, хаягийн самбар байршуулав. Хашаа, хайсыг уурхайн дотоод нөөц бололцоогоор шинэчилсэн бөгөөд самбарт **79200 төгрөг** зарцуулсан бөгөөд уг ажилд 1 автомашин, 4 ажилтан оролцлоо.







*Зураг 165. Буган хөшөөний хашаа хайсыг засаж, самбар байрлуулж буй нь*

## **7.2. Төслийн талбайд шинээр илэрч буй хадны сүг зурагнуудын тооллогыг сумын Байгаль орчны мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулж, мэдээллийн санд оруулах**

Тус компанийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хөшөө дурсгал 1, булш хиргисүүр 1, хадны зураг нь 2 газраас олдсон бөгөөд олон хэсгээс бүрдсэн цогцолбор байдлаар байгааг илрүүлэн тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулав.

- ✚ Уурхайн кемпийн талбайд ургаа хадан дээр 4 хэсэг сийлбэрээс бүтсэн, сүргээрээ байгаа янгир ямаа, хүн, үл мэдэгдэх олон дүрсүүд, мөн дангаараа байх янгир ямаа зэргийг сийлбэрлэж дүрсэлсэн байна. Энэ хүү хадны зураг байх хад нь байгалийн аясаараа өнгөн хэсэг нь хуурах, хажуу талаас цууралт үүссэн байна.





ЗУРАГ 166. КЕМПИЙН ТАЛБАЙД ОРШИХ ХАДНЫ БИЧЭЭС

- ✚ 5-р биет рүү явах замын зүүн талд орших багавтар уул толгодын ургаа хадны хэсгүүдэд уртаашаа 200м, өргөн 300м газрыг хамарсан өөр хоорондоо адилгүй хадны сийлбэр дүрсүүд, 1ш булш хиргисүүрийг олж тогтоон, тэмдэгжүүлэлт хийлээ.
- ✚ Эхний хэсэгт байх хадан цохионы энгэр ээвэр газрын хадны сийлбэрүүд нь бүдгэрсэн, нар салхины элэгдэлд өртөж, хад нь эмтэрч гэмтсэн байна. 2, 3 дахь хэсгийн хадны сийлбэрүүд нь дүрс тод элэгдэл гэмтэл бага хэдүй ч хадны өнгөн хэсэг хуурч байгаа байдал ажигдлаа. Ихэнхдээ сүргээрээ орших янгир ямаа, хүн, амьтан, тамганы дүрслэл, нүүдэл хийж буй дүрслэлүүд илүү тод байна. Эдгээр дүрсүүдийн ойр орчинд үл ойлгогдох дүрсүүд мөн их байна. Амьтад, хүн, янгир ямааг дүрслэхдээ амьтдынхаа бүх биеийг цоолборлож дүрслэхээс гадна амьтны биеийн тигээр хөвөөлөн цохиж бүтээсэн нь эдгээр сийлбэрүүд өөр өөр он цагийн үед бүтээгдсэн байгааг илтгэнэ.
- ✚ 5-р биет рүү замын зүүн талын хэсэгт орших булш хиргисүүр



*Зураг 167. 5-р биетийн хойд талд орших хадны бичээст самбар байрлуулсан байдал*



*Зураг 168. Хадны бичээсүүд*





ЗУРАГ 169. Булш, ХИРГИСҮҮР

**Дүгнэлт:** Кемпийн баруун хэсэгт орших хадны сийлбэрүүд нь нийт 4 чулуун дээр дүрслэгдсэн 4 хэсэг сийлбэрүүд байна. 5-р биет рүү явах замын зүүн талд 3 өөр газарт орших өөр хоорондоо зайтай байх хадан цохион дээр дүрслэгдсэн 10 гаруй хэсгээс бүрдэх хадны сийлбэрүүд байна. Хадны сийлбэрүүдийн дүрсийг авч архивлан хадгалав.

## 8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 8.1. Техник технологийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг үйлдвэрийн цех, хэсгүүдэд ажлын байр тус бүрээр байршуулах, бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгах, хянах

ХАБЭА-ны ажилтан Баяжуулах үйлдвэрийн цех хэсгүүдийн аюулгүй ажиллагааны заавруудыг шинэчлэн ажлын байран дээр нүдэнд ил харагдахуйц газарт байрлуулж, ажлын байр тус бүрийн ажуулгүй ажиллагааны зааварчилгааг шинэчлэн батлуулж мөрдөж ажиллаж байна. Мөн үйлдвэр болон уулын ажил явагдах үед тухай бүр ажлын байрны үзлэг шалгалтыг хийж байна.

ХАБЭА-ны мэргэжилтэн: Уурхай болон Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны явцад өдөр тутмын хяналт тавьж ажиллан, илэрсэн зөрчил дутагдлыг цахимаар байнга мэдээлэн хариу арга хэмжээ авч ажиллаж байна.

✚ Өдөр тутмын хяналтын талаар цахимаар мэдээлэл хүргэж буй байдлаас:

Насанбуян:

ХБҮйлдвэр болон Уулын ажил, ажилчдад ажлын байрны үзлэг шалгалт хийлээ. 1. Ажилчид нарядын дагуу ажил үүргээ гүйцэтгэж байна 2. ХАБ зөрчигдөөгүй хувцас хамгаалах хэрэгсэл, нэг бүрийн хамгаалах хэрэгслээ бүрэн өмссөн. ХБҮйлдвэрт 1. Ажлын байрны эмх цэгц зарим газарт алдагдсан. 2. Цахилгааны шит самбарууд онгорхой орхигдсон. Хүрж болохгүй гэсэн пайз тэмдэг байрлуулах шаардлагатай. 3. ХБҮйлдвэрийн бутлуурын конус хэсгийн ойр орчимд хаягдал төмрүүд хөглөрсөн. Эмх цэгцэнд оруулна уу. 4. Хаягдлын далангийн хаалт хашилтыг яаралтай босгож тавих. 5. Лабораториор ажилчид ажлын болон ажлын бус цагаар дэмий сэлгүүцэх, ам цангасан гэх шалтгаанаар орж цай, кофе уух зорилгоор чөлөөтэй орж гарч байна.

Зөвшөөрөлгүй хүн нэвтрэх хориотой хэсэг учраас энэ тал дээр @Уулын мастер @Т. Гарамбазар онцгой анхаарал тавьж дахиж ийм асуудал гарвал зөрчилд тооцож сахилгын арга хэмжээ авч ажиллаарай.

Насанбуян:

[@Уулын мастер](#) Воркшопын засварын хэсгийг УАА- Ажилчдад шаардлага тавьж эмх цэгцэд оруулна уу

Насанбуян:


ХБҮ, УАА-ын өдрийн ээлж болон шөнийн ээлжын ажилчдад ажлын байрны үзлэг шалгалт, хяналт тавьж ажиллаа. 1. Ажилчид нарядын дагуу ажил үүргээ гүйцэтгэж байна. 2. Хаягдал дамжуулах шланк задарснаас болж засварын ажил явагдаж байна 3. ХАБ зөрчигдөөгүй ажилчид хоорондоо уялдаа холбоо сайтай ажиллаж байна. 4. УАА-ын өөрөө буулгагч машины дугуйг солих үед Домкрат нь доошоо алддаг, бусад домкратын ажиллагаа хэвийн бус! Домкратаар өргөсөн үед дугуй солих болон машин доогуур ямар нэг засвар үйлчилгээ хийх үед хүний дээрээс алдах эрсдэлтэй байгаа учир яаралтай шинийг захиж өгнө үү.

2

**Кэмп гал тогоо хоол үйлдвэрлэлийн хэсэгт 1т: Filter ус шүүгчийн хэрэглээний хугацаа дуусаж усаа шүүхээ больсон тул Filter солих. 2т: Хөргүүр болон хөлдөөгчний үлээгч сэнсний төхөөрөмж халаж доголдох болсон тул үзлэг оншилгоо хийж яаралтай засвар үйлчилгээ хийлгэх.**

Насанбуян:

ХБҮйлдвэрийн шөнийн ээлжийн ажилчдад хяналт тавьж ажиллаа. 1. Ажилчид нарядын дагуу ажил үүргээ гүйцэтгэж байна. 2. Хувцас хамгаалах хэрэгслээ бүрэн гүйцэт өмссөн. 3. Ажлын байрны эмх цэгц алдагдаагүй. 4. ХАБ-ын ямар нэг зөрчил илрээгүй. 5. ИТА-ны удирдлага доор уялдаа холбоо сайтай ажиллаж байна.







Зураг 170. Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны зааврыг шинэчилсэн байдал







Зураг 172. Гал унтраагуурыг байрлуулж буй нь



**8.3. Галын хорны ажиллагааг тогтмол шалгаж карт хөтлөлтийг тогтмолжуулан тэмдэглэл хийж байх**

Тайлангийн хугацаанд галын хорны пайз **30ш-ийг 99000 төгрөгөөр** захиалан авч, үйлдвэр болон засварын цехэд байх гал унтраагууруудад хяналтын пайз хийж, сар бүр гар унтраагуурыг шалган тэмдэглэл хийж байна.







*Зураг 173. Гар унтраагуурын хяналтын пайз*

#### **8.4. Галын аюулаас урьдчилан сэргийлэх багаж хэрэгслийн галын сарайн засвар хийх /багаж хэрэгслийн нөхөн бүрдүүлэлт хийх/**

Уурхайн хэмжээнд нийт 5 галын сарай байгаа бгөөд ШТС-ын дэргэд байрлах болон баяжуулах үйлдвэрийн дотор байрлах галын сарайнуудыг засварлан, багаж хэрэгслүүдийг будаж нөхөн бүрдүүлэлт хийв.





Зураг 174. Галын сарайд багаж хэрэгсэл байрлуулж, шинэчилсэн байдал

### 8.5. Галын хорны тэмдэг тэмдэглэгээ хийж байршуулах

Баяжуулах үйлдвэр болон засварын цех, ажилчдын амрах байр, гэрүүдэд байрлуулсан гал унтраагуурын хэвийн ажиллагааг шалган тэмдэглэх пайзыг гал унтраагуурт зүүж, сар бүр хянаж тэмдэглэл хөтөлж байгаа бөгөөд гар унтраагуур байрлуулсан газарт галын хорны тэмдэг тэмдэглэгээ бүрэн байрлуулсан.








Зураг 175. Галын хорны тэмдэг, тэмдэглэгээг байрлуулсан байдал

### 8.6. Үйлдвэрийн дотоод цахилгаан сүлжээний бүрэн бүтэн байдалд үзлэг, засвар үйлчилгээ хийх

Баяжуулах үйлдвэрийн дотоод цахилгаан сүлжээний холболтын бүрэн бүтэн байдлыг үйлдвэрийн цахилгаанчин болон цахилгааны инженер байнгын хяналт тавин ажиллаж, шаардлагатай үед засвар үйлчилгээг хийж гүйцэтгэж байна.



Зураг 176. Үйлдвэрийн цахилгааны хяналт хийж буй нь

### 8.7. 2023 оны Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж ажиллах

Хөхбулаг уурхай болон Баяжуулах үйлдвэрийн 2023 оны Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Уул уурхайн аврах 09 дүгээр ангийн цахим хаягаар илгээн хянуулж, захирагчаар батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.



Зураг 177. Төлөвлөгөө батлуулсан байдал

### 8.8. Байгалийн аюул, гамшигийн үед авах арга хэмжээний талаар мэдээлэл ажилчдад өгөх, урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргах

2023 онд Уулын ажил болон Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа тогтвортой явагдаагүй бөгөөд тайлангийн хугацаанд байгалийн аюул, гамшигт үзэгдэл болоогүй. Мөн уурхайн хэмжээнд цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг [weather man](#) гар утасны апп болон facebook- цахим орчины мэдээллээс авч ажилчдын групп чатуудаар нийт ажилчдад хүргэж ажиллаж байна.

### 8.9. Өвлийн улиралд үйлдвэрийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл байдлаар хангах, хөлдөлт үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах

Уурхайн хэмжээнд халаалтын 3 нам даралтын зуух ажилладаг бөгөөд галчаар нийт 12 ажилтан ажиллаж, халаалтын шугам сүлжээний бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, хавар, намрын улиралд шугам сүлжээний их засварын ажил хийж гүйцэтгэсэн. 2023 оны 1-р сараас хаврын халаалт дуустал халаалтын ажиллагаа хэвийн явагдсан. 10-р сарын 1-ээс галч болон тусдах ажилд чыг ажилд нь оруулж өвлийн улиралд бэлдэх шуам сүлжээнүүдийн засварын ажил хийх, мөн нүүрсний татан авалтуудыг хийж, халаалт хэвийн байна.

### 8.10. Химийн бодис хадгалах аглуулах, шинжилгээний өрөөнд эмийн сан болон галын хорыг стандартын дагуу байршуулах



Химийн бодис хадгалах агуулахад 2ш, шинжилгээний өрөөнд 1ш эмийн сан [363000](#) төгрөгөөр авч байрлуулан, шинжилгээний өрөөнд нийт 4ш галын хор, химийн бодисын агуулахад 2ш галын хор байрлуулаад байна.



*Зураг 178. Химийн бодис хадгалах агуулахад байрлуулсан эмийн сан*





Зураг 179. Шинжилгээний өрөөнд байрлуулсан эмийн сан, галын хор





Зураг 180. Химийн бодис найруулах хэсгийн эмийн сан

### 8.11. Химийн бодисын аюулгүй ажиллагааны самбар, тэмдэг тэмдэглэгээг шинээр хийлгэж байршуулах

Баяжуулах үйлдвэрийн химийн бодис найруулах хэсэгт 2 ш самбар, шинжилгээний өрөөнд химийн бодисын аюулгүй ажиллагааны самбар 2ш-ийг нүдэнд харагдахуйц газар байрлуулсан. Нийт 4ш самбар, **132000 төгрөг** зарцуулсан.





Зураг 181. Химийн бодисын аюулгүй ажиллагаанб самбар байрлуулсан байдал







Зураг 182. Химийн бодисын тэмдэг, тэмдэглэгээ байрлуулсан байдал

## 8.12. Химийн бодис хадгалах агуулахуудыг засварлаж, стандартын дагуу тохижуулах /агуулах нь тухайн бодисын ХАЛМ-д заасан шингээгч материалаар /зориулалтын шингээгч, хуурай элс, тогтворжуулагч гэх.мэт/ хангагдсан байна/

Манай компани нь **MNS 6458:2014** стандартын дагуу химийн бодисын агуулахыг барьж байгуулан химийн бодис тус бүрийг ангилан хадгалж байна.

- ✚ Химийн бодис хадгалах агуулахын дээврийн засвар хийж, борооны ус орохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авав.
- ✚ 2 агуулахад хадгалагдаж буй химийн бодисуудыг стандартын дагуу тусгаарлалт хийж, зориулалтын тавиур тавьж бодисуудыг хурааж цэгцлэв. Мөн гэрэлтүүлэг шинээр тавьсан. Эмийн сан 2 ш, шаардлагатай үед холбоо барих ажилчдын утасны дугаар, химийн бодисын ХАЛМ, хаяг зэргийг шинээр байрлуулан тохижуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Шинжилгээний өрөөний 2 агуулахыг цэгцлүүлж цэвэрлүүлэх арга хэмжээ авсан.
- ✚ Баяжуулах үйлдвэрийн химийн бодис найруулах хэсэг, химийн бодисын агуулах, шинжилгээний өрөөнд тус тус химийн асгаралтаас хамгаалах иж бүрдлүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, шинээр 1ш асгаралтаас хамгаалах иж бүрдэл авч бүрэн болгон, үйлдвэрийн баяжуулагч инженерт хүлээлгэж өглөө. Мөн ашиглах заарыг танилцуулав. Нийт **330000 төгрөг** зарцуулсан.



*Зураг 183. 1-р агуулахыг тохижуулж буй нь*





*Зураг 184. 2-р агуулахыг цэгцэлсэн байдал*








Зураг 185. Химийн асгаралтын иж бүрдлүүд

### 8.13. Химийн хорт бодистой харьцах үеийн өдөр тутмын зааварчилгааг батлуулж, цех хэсгүүдэд байршуулах


✚ Баяжуулах үйлдвэрийн химийн бодис найруулах хэсэг, шинжилгээний өрөө, химийн бодис хадгалах агуулахуудад химийн бодистой харьцах өдөр тутмын зааварчилгааг шинээр боловсруулан нүдэнд ил харагдахуйц газар байрлуулан ажиллаж байна.




Зураг 186. Аюулгүй ажиллагааны заавар

8.14. Химийн бодисын зарцуулалтын бүртгэлийг өдөр бүр хөтлөх, зарцуулалтын тайланг хугацаанд нь гаргах, дээд байгууллагад химийн бодисын зарцуулалтын тайланг хүргүүлэх

- ✚ Баяжуулах үйлдвэрийн технологи болон шинжилгээнд хэрэглэж буй химийн бодисын зарцуулалт хөтлөх бүртгэлийн дэвтэр хэвлэн өгч, зарцуулалтыг өдөр бүр хөтөлж байх заавар өгч ажиллаа.
- ✚ Химийн бодисын тайланг хуулийн хугацаанд гаргаж дээд байгууллагад хүргүүлэв.



Зураг 187. Зарцуулалтын бүртгэлийн дэвтэр



Зураг 188. Химийн бодисын тайлан

### 8.15. Химийн бодис хадгалах агуулахын хаяг шинээр хийлгэж байршуулах

- ✚ Баяжуулах үйлдвэрийн химийн бодис хадгалах 2 агуулах, үйлдвэрт химийн бодис найруулах хэсэгт 2 хаяг, 4ш хаяг шинээр захиалан хийлгэж байршуулав. Нийт **66000 төгрөг** зарцуулав.





Зураг 189. Хаяг байрлуулсан байдал

**8.16. Үйлдвэрт хэрэглэгдэж буй химийн бодисын хор аюулгүйн лавлах мэдээллийг бодис бүрээр шинэчлэн хийж нүдэнд ил харагдахуйц байршуулах /ажилтан нэг бүр тухайн бодис, хольц, хаягдлыг үстгах аргачлал, тээвэрлэх арга зэргийг сайтар үншиж танилцан мөрдөх/**

- ✚ Баяжуулах үйлдвэрийн технологит 4 төрлийн химийн бодис, шинжилгээнд 5 төрлийн химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөлтэй бөгөөд химийн бодис тус

бүрийн ХАЛМ-ийг шинэчилэн боловсруулж, уурхайн ерөнхий инженерээр батлуулан химийн бодисын агуулах, шинжилгээний өрөө, баяжуулах үйлдвэрийн химийн бодис найруулах хэсэгт тус тус байрлуулан ажиллаж байна.



Зураг 190. Химийн бодис тус бүрийн ХАЛМ байрлуулсан байдал

**8.17. Аюултай хог хаягдлын агуулахад тэмдэг тэмдэглэгээ хийх, гэрэлтүүлэг болон лангуутай болгох, хог хаягдлыг стандартын дагуу хаягжуулж хадгалах**



- ✚ Аюултай хог хаягдлын агуулахыг хаягжуулан, аюултай хог хаягдлын сав баглаа боодлыг ангилан цэгцэлж стандартын суурь тавьж хураан, агуулахын дээврийг борооны ус орохоос сэргийлэн засварлаж, тэмдэг тэмдэглэгээ байрлуулав.





Зураг 191. Аюултай хог хаягдлын агуулахыг цэгцэлсэн байдал

8.18. Аюултай хог хаягдлаа тээвэрлүүлэх гэрээ байгуулан, хуримтлал үүссэн үед тээвэрлэлт хийлгэх, аюултай хог хаягдлын тайланг хугацаанд нь гаргаж дээд байгууллагад хүргүүлэх

- ✚ Аюултай хог хаягдал тээвэрлүүлэх Т-23/011, VMR-05/23 тоот гэрээ, Аюултай хог хаягдал шилжүүлэх Ш-23/011, VMR-04/23 тоот гэрээнүүдийг Цэцүүх трейд ХХК-тай байгуулан ажиллаж байна. Аюултай хог хаягдлын тайланг хуулийн хугацаанд БОАЖ-ын яаманд хүргүүлээд байна.







*Зураг 192. Аюултай хог хаягдал хүлээлгэн өгсөн баримтууд болон тээвэрлэж буй нь*

**8.19. Химийн бодисын болзошгүй осол, аваарын үед ажиллах ослын төлөвлөгөөг боловсруулан холбогдох чиглэлийн үлсын байцаагчаар батлуулан мөрдөж ажиллана.**

Төлөвлөгөөг боловсруулсан боловч батлуулаагүй болно.

**8.20. Хаягдлын далангийн байгууламжид ажлын байрны үзлэгийг тодорхой давтамжтайгаар хийх, шүүрэл алдагдсан тохиолдолд яаралтай арга хэмжээ авч засварлах**

Баяжуулах үйлдвэрийн дарга болон ажилчдад хаягдлын далангийн байгууламжийн бүрэн бүтэн байдалд байнгын үзлэг шалгалт хийж байх үүрэг өгч ажилласан ба тайлангийн хугацаанд хаягдлын далангаас шүүрэл үүсээгүй байна.





Зураг 193. Хаягдлын далан

**8.21. Хаягдлын далангийн байгууламжид усны байгууламжийн мэргэжлийн байгууллагаар жил бүр нарийвчилсан үзлэг шалгалт (хулдаасны бүрэн бүтэн байдал, далангийн захын хэсгээр зутан дүүргэлтийн хэмжээ хэтэрсэн эсэх, далангийн үндсэн хэсгийн бат бэх) хийлгэх**

2023 онд Баяжуулах үйлдвэр нь тогтмол үйл ажиллагаа явуулаагүй тул хагдлын далангийн байгууламжинд Мэргэжлийн байгууллагын үзлэг шалгалт хийлгээгүй бөгөөд хаягдлын далангийн үлдэгдлээс 1 удаа дээж авч ХАНЛАБ итгэмжлэгдсэн лабораториор MNS5850:2019 стандартаар шинжлүүлсэн болно. Хаягдлын багууламжид зутан дүүргэлт хэтрээгүй хэвийн байна. /Дээрх зургаас тодорхой харагдана/ Шинжилгээний дүгнэлтээр ЗДХ-ээс хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна.



**ХАНЛАБ ХХК**  
 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17-р хороо, Богд Жалзандамба  
 гууламж 3/6 тоот, Хан Рашань компанийн байр  
 Утас: 701.99968, 99995316  
<http://www.khanlab.mn>



**ИТЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**

ЗАХИАЛГА №: 2023/1325-2

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: **ВОЯЖЕР МИНЕРАЛС РЕСУРС ХХК**

Хөрс, I

№	ЛАБОРАТОРИЙН ДЭГЛЭЭ	ДЭЭЖИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ	ЭЛЕМЕНТ, %										ЭЛЕМЕНТ, мг/кг				Хөрс, I	
				Na	Ca	Mg	K	Fe <sub>total</sub>	As	Ba*	Be	Bi	Cd						
1	J-15535	№3 Хаяглалт овоого Угилдврийн хаягдал	өрс	2.24	4.91	0.99	2.36	2.94	16.39	856.1	1.80	<10.0	<1.0	20.00	-	-	-	-	2.00
				MNS5850:2019															

№	ЛАБОРАТОРИЙН ДЭГЛЭЭ	ДЭЭЖИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ	ЭЛЕМЕНТ, мг/кг																		
				Co	Cr	Cu	La	Li	Mn	Mo	Ni	P	Pb									
1	J-15535	№3 Хаяглалт овоого Угилдврийн хаягдал	өрс	12.34	32.95	39.52	28.83	21.54	505.2	<5.0	14.72	528.5	7.79	50.00	150.0	100.0	-	-	5.00	150.0	-	170.0
				MNS5850:2019																		

№	ЛАБОРАТОРИЙН ДЭГЛЭЭ	ДЭЭЖИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ	ЭЛЕМЕНТ, мг/кг																		
				Sb	Se	Sr*	Ti	V	Y	Zn	Zr*											
1	J-15535	№3 Хаяглалт овоого Угилдврийн хаягдал	өрс	<10.0	<5.0	550.6	2752	61.35	9.82	52.56	57.43	809.0	-	-	150.0	-	-	-	-	-	-	-
				MNS5850:2019																		

Чанарын мөнөөр: Д. Пүрэвжаргал



Соригтын гу дун үнэмэлт тухайн доохи хэргийг дуудуулах асуудлыг манай лаборатори хариуцахгүй болно.

ХҮЛЭЭН АВСАН ОГНОО: 2023.08.21  
 ШИНЖИЛЭН ОГНОО: 2023.09.04

ДЭЭЖ БОЛБЕСРУУЛАЛТ: хийгдсэн.  
 ХУУДАСНЫ ТОО: 1

Хамгийн амжилттай танил талархсан.

Хуудан 1-4

Зураг 194. Хаягдлын шинжилгээний дүгнэлт

**8.22. Эргэлтийн усан сангийн шугам хоолой, насосны бүрэн бүтэн байдлыг байнга хянах, шүүрэлт үүссэн тохиолдолд яаралтай арга хэмжээ авах**



- ✚ Эргэлтийн усан сангийн шугам хоолойны бүрэн бүтэн байдалд худгийн насосчин болон үйлдвэрийн ээлжийн ажилчид байнгын хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд тайлангийн хугацаанд шүүрэлт үүсэх, эвдрэл гэмтэл гараагүй байна.

## **9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

### ***Хог хаягдлын хяналт, удирдлага, зохион байгуулалт***

Хог хаягдлаа хэрхэн бага ялгаруулах, ангилах, ялгах талаар сургалтыг ажилчдад байгуулна. Уг уурхай нь 50-71 ажилчидтай ажилласан бөгөөд нэг ажилчнаас хоногт дунджаар 0.3 кг ахуйн хатуу хог хаягдал гарна гэж үзвэл хоногт 21.3 кг, жилд 5.0 тн нийт хаягдал гарна. Уурхай болон баяжуулах үйлдвэрээс гарах хаягдлыг ангилж ахуйн хогтой хамт түр хадгалах ба орон нутгийн Захиргааны байгууллагатай байгуулсан гэрээний дагуу тээвэрлүүлэх ажлыг зохион байгуулав.

Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад химийн хорт бодисын сав баглаа боодлын хаягдал гарсаныг тусгай агуулахад хадгалан, Мэргэжлийн эрх бүхий байгууллагад хүлээлгэж өгөв. Технологийн бус, сонор сэрэмжгүй, сахилга хариуцлагагүй үйл ажиллагааны улмаас хаягдлын далан шүүрэх, нефтийн бүтээгдэхүүн алдагдаж, хөрс, ус агаар орчныг бохирдуулах болзошгүй байдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг сайтар төлөвлөж ажиллана.

Үйлдвэрийн ашиглалтын ажлын үед ашиглагдаж буй машин, тоног төхөөрөмжүүдэд зохих хуваарийн дагуу техникийн үйлчилгээ хийх үед ажилласан тос, тосолгооны хаягдал материалыг тусгай саванд хийж түр цэгт хадгалж байна.

Үйлдвэрийн суурингаас гарах ахуйн зориулалтаар хэрэглэсэн бохир ус, шингэн хаягдал орчныг бохирдуулах нөлөөтэй.

#### *Хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах арга хэлбэр:*

Тус үйлдвэрийн ашиглалтын үйл ажиллагаанаас гарах хаягдлын сангийн хатуу хаягдлыг жилд 1 удаа түрж хаягдлын далангийн нөхөн сэргээлтэд эргүүлэн ашиглана.

Үйлдвэрийн гаралтай металл хаягдлыг тусгай талбайд хурааж, тээвэрлэж, 2-догч түүхий эд болгон борлуулах арга хэмжээг авна.

Мөн ажиллагсдын байрлах байрнаас хатуу хог хаягдал гарна. Үүнийгээ гэрээ байгуулан тогтмол хугацаанд хогийн цэгт тээвэрлүүлж, гарсан зардлыг бүрэн барагдуулж ажиллана.

#### *Шингэн хаягдал цэвэрлэгээ, арга хэлбэр, зайлуулалт:*

Тус үйлдвэр нь үйлдвэрлэлийн зориулалтаар усыг хэрэглэхдээ эргүүлэн ашиглах процессоор хэрэглэнэ. Ахуйн шингэн хаягдлыг тусгай бэлтгэсэн нүхэнд хаяхын зэрэгцээ бие засах газрыг эрүүл ахуйн талаас нь стандартын шаардлага хангахуйц ус нэвчихгүй мемберан дэвсэж доторлосон бохир хаях цэгт нийлүүлж, Мэргэжлийн байгууллагатай бохир ус зайлуулах гэрээ байгуулан ажиллаж байна.

### **9.1. Ахуйн хог хаягдал хадгалах цэгийн хаягийг шинэчлэх, хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх сургалт зохион байгуулах**

- ✚ Хаягдал бохир усны цэг, хог хаягдлын тэмдэгийг шинэчилсэн. Нийт **95700 төгрөг** зарцуулав.

- ✚ Уурхайн нийт ажилчдад Хүний нөөцийн менежер, ХАБЭА-ны инженер нартай хамтран “Хог хаягдлыг ангилах, хадгалах, ашиглах” сэдвээр сургалт зохион байгуулав.



*Зураг 195. Шинэчилсэн хаяг болон тэмдэг*



*Зураг 196. Уурхайн ажилчдын сургалт*





## 9.2. Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, оффис, автозогсоол зэрэг газарт байрлуулах

Уурхайн санхүүгийн хүндрэлээс шалтгаалж шинээр хог хаягдлын сав суурьлуулаагүй. Хуучин хог хаягдлын савыг будаж, засвар үйлчилгээ хийсэн. Баяжуулах үйлдвэр, засварын цех, ажилчдын амрах газруудад тамхи татах цэгийн тэмдэг тэмдэглэгээ, хог хаягдлын саваар бүрэн хангагдсан байна.



Зураг 197. Тамхи татах цэг болон хогийн сав байрлуулсан байдал

### 9.3. Нийтийн бие засах газар болон ахуйн бохирын байгууламжийн орчинд ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх


Манай компани нь Бөмбөгөр сумын Засаг даргын 2019 оны 10 сарын 21-ний өдрийн А/124 тоот захиармжаар Хөх булгийн уурхайн хог хаягдал, бохир ус зайлуулах цэгийг тогтоолгон мөрдөн ажиллаж байна. Уурхайн хэмжээнд нийтийн ариун цэврийн газрыг цогцоор нь шийдсэн бөгөөд эрэгтэй, эмэгтэй ОО, усанд орох шүршүүр, саун, угаалгын газар, гар нүүрийн



угаагуур зэргээс бүрдэнэ. Бохир ус хадгалах цооногийг стандартын дагуу барьж байгуулан хөрсөнд нэвчихээс сэргийлсэн геомемберанан доторлогоотой, бохир соруулах тусгай цооног, агааржуулалтын хоолой гаргаж битүүмжлэлийг хангасан ба үйлчилгээний ажилтан бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллаж байна. Ахуйн ашиглалтаас гарсан бохирыг Баянхонгор аймгийн “Чандмань Баянхонгор” ХХК-тай Бохир ус татан зайлуулахад хамтран ажиллах №2023/15 дугаар бүхий гэрээ байгуулан **11тн бохир** соруулуулаад байна. Уг гэрээт ажилд **990000 төгрөг** зарцуулсан. ОО-ын ариутгал, цэвэрлэгээг үйлчилгээний ажилчид хариуцаж 7 хоногтоо 1 удаа их цэвэрлэгээ хийж хэвшсэн. Үйлчилгээний ажилчдыг 7 хоног бүр цэвэрлэгээний хэрэгсэл болон ариутгалын бодис, багаж хэрэгслээр ханган, ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.



*Зураг 198. Нийтийн бие засах газар /эр, эм/*








Огноо/Date: 2023.09.28 14:45:25				
Шилжүүлгийн мэдээлэл/Transaction Information Журналын/Journal No: 23384678				
Системийн огноо/System Date: 2023.09.28 14:45:25				
Дт/From	IBAN/Дансны/ Картын дугаар (BAN)/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханца/Rate
	5111037360	ВОЯЖЕР МИНЕРАЛ РЕСУРСЕС	990,000.00 MNT	1.00
/ Есөн зуун ерэн мянган төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No	Банкны нэр/Bank Name	Дүн/Amount	Ханца/Rate
	05	Хяан Банк - Хаан банк	990,000.00 MNT	1.00
	IBAN/Дансны/ Картын дугаар (BAN)/Account/Card Number	Нэр/Name		
	0225031142	ЧАНДМАНЬ БХР ХХК		
Туйлгээний утга/Transaction description: ЕВ-Бөхир соруулах гараат аж РД:5502292				
